



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай.


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29, 31 дүгээр зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам” –ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулж ажиллахыг ажлын хэсэг /Д.Ариунбаатар/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан ажлын хэсэг томилох тухай нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2018 оны А/70 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай


ДАРГА



Ч.ОДНАСАН

115050000195

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2019 оны 09 сарын 19 өдрийн
158 дугаар тушаалын хавсралт



ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Д.Ариунбаатар	/Орлогч дарга/
Гишүүд:	Н.Раднаасэд	/Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн/
	Б.Эрдэнэмох	/Төлөөлөл менежмент, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн/
	О.Уранчимэг	/Бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн/
	Д.Батбаяр	/Захиргаа Санхүүгийн хэлтсийн нярав/
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхбаатар	/Бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн/